



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/96

Шивээговь сум

Хагас жилийн малын түүвэр судалгааг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.г, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/169 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд 2021 оны хагас жилийн малын түүвэр судалгааг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 22-ны өдрүүдэд зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Ч.Сугармаа (Засаг даргын орлогч дарга)
Нарийн бичгийн дарга:	О.Даваажав (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Гишүүд:	Д.Отгонбаатар (Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менемжент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн) Н.Амаржаргал (1 дүгээр багийн Засаг дарга) С.Отгонбаатар (2 дугаар багийн Засаг дарга) Б.Баярцэцэг (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Судалгаа явуулахтай холбогдуулан түүврээр сонгогдсон өрхийг тооллогод бүрэн хамруулах арга хэмжээ авч, тооллогын ажлыг удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж, товлосон хугацаанд зохих журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг комиссын дарга /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

421210480